

Баяндэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газрын
2022 оны 12 дугаар сарын мэдээ

2022.12.25

Нэг: Удирдлага, зохион байгуулалтын талаар:

а/ Сумын ИТХ-ын чиглэлээр: ИТХ-ын төлөөлөгчдийн ээлжит 4 дүгээр хуралдааныг 2022 оны 12 дугаар сарын 16 -нд хуралдуулж доорх асуудлуудыг хэлэлцэж олонхийн саналаар баталлаа.

Сумын ИТХ-ын 2022 оны үйл ажиллагааны товч танилцуулга, Сумын засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилт, Сумын 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт, 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний төсөл, Сумын 2021 оны төсвийн гүйцэтгэл, 2023 оны төсвийн төсөл, Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөл зэргийг хэлэлцсэн.

б/ Тамгын газрын төрийн удирдлагын ажлын чиглэлээр:

Тухайн сард дээд газраас 25 албан бичиг ирсний 6 нь хариутай, хугацаа хоцорсон албан бичиг байхгүй болно.

2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А\216 тоот захирамжаар тус сумын монголын залуучуудын холбооны салбар зөвлөлийн бүтэц бүрэлдэхүүнийг шинээр зохион байгуулж дэмжлэг үзүүлээ.

Мөн өдрийн А\220 тоот захирамжаар ар гэр амьдралын түвшинг харгалзан хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настанд түлээ нүүрс бэлтгэхэд нь зориулан 10 ахмадад мөнгөн тусламж үзүүлсэн.

Хоёр: Төсөв санхүүгийн чиглэлээр: Орон нутгийн Төсөвт байгууллагын санхүүжилтийг бүрэн хийж зарлагын гүйлгээг бүгд хийгдсэн.

Орон нутгийн төсөвт байгууллагын үлдэгдлийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд, Улсын төсвийн байгууллагын тогтмол зардлын үлдэгдлийг аймгийн орон нутгийн ерөнхий орлогын дансанд тус тус төвлөрүүлсэн.

Жилийн эцсийн хүн ам мал тооллогын ажлыг зохион байгуулан ажиллаж дүн мэдээг нэгтгэж статистикийн хэлтэст бүрэн тушаасан болно.

2021 оны төсвийн гүйцэтгэл 2023 оны төсвийн төслийг сумын ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж, тогтоол болон сарын хуваарийг сангийн яамны цахим санд мэдээллийг бүрэн оруулсан. Шилэн дансны мэдээллийг цахим санд мэдээлсэн

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд: Аймгийн цагдаагийн тасгаас зарласан “Намайг алгас”, “Нандин бүхнээ хайрлая” аяны хүрээнд сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, Цагдаагийн тасагтай хамтран эцэг эхчүүд болон байгууллагын багш ажилчдын хамруулан сургалтыг зохион байгууллаа.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Ерөнхий боловсролын сургууль: 2022 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Сүхбаатар аймагт зохион байгуулагдсан “Хун” хүүхдийн урлагийн наадамд 96 ангийн сурагч Ц.Энхжин гоцлол хөгжмөөр 2-р байр эзэллээ.

11 дүгээр сарын 25-27-ны өдрүүдэд Сүхбаатар аймагт мэдээлэл технологи хариуцсан сургалтын менежер Ш.Өлзийбүрэн, мэдээлэл технологийн багш

Ч.Эрдэнэсүвд нар “Орон нутгаас дэлхий рүү-мэдээллийн технологийн цоорхойг нөхөх нь” Python програмчлалын хэлний мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдлаа.

12 дугаар сарын 01-ны өдрийн ДОХ-той тэмцэх өдрийг тохиолдуулан “Гэр бүл төлөвлөлт, хүсээгүй жирэмслэлтээс сэргийлэх арга зам, бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх” мэдээллийг 10-12 дугаар ангийн 98 сурагчдад Биологийн багш М.Отгонтуяа, сургуулийн эмч Р.Тунгалаг, ЭМТ-ийн эмч Ч.Уранчимэг нар хамтран хүргэлээ.

12 сарын 06-ны өдөр 9 дүгээр ангийн нэрэмжит гар бөмбөгийн тэмцээн амжилттай зохион байгуулагдлаа.

12 сарын 07-ны өдөр 8-9 дүгээр ангийн 110 сурагчидтай цагдаагийн байгууллагын албан хаагчид уулзаж мэдээлэл хүргэлээ.

12 дугаар сарын 16-ны өдөр сурагчдын нэгдүгээр улирлын амралт эхэллээ. 12 сарын 17-ны өдөр Сүхбаатар аймагт зохион байгуулагдсан “Судар эгшиглэн” арга хэмжээнд 5в ангийн сурагч Т.Энхрийлэн, 5б ангийн сурагч Б.Удвал, 10в ангийн сурагч А.Буманханд, 6а ангийн сурагч А.Цэндхорол, МХУЗ багш Б.Баярсайхан нар оролцлоо.

Сүхбаатар аймагт мэдээлэл технологи хариуцсан сургалтын менежер Ш.Өлзийбүрэн, мэдээлэл технологийн багш Ч.Эрдэнэсүвд нар “Орон нутгаас дэлхий рүү-мэдээллийн технологийн цоорхойг нөхөх нь” Python програмчлалын хэлний мэргэжил дээшлүүлэх 2 дах удаагийн сургалтад хамрагдлаа.

ЕБС-ийн багшийн “Заах аргач”, “Тэргүүлэгч зэрэг-ийг сунгах, шинээр орох хэлэлцүүлэгт тайлан 12 дугаар сарын 19-ны өдөр боллоо.

2022 оны 12-р сарын 21-22-ны өдрүүдэд "Би залуу багш" хөтөлбөрийн танхимын сургалтад багш Б.Манд-Ууган, Б.Пүрэвдарь нар оролцлоо.

12 дугаар сарын 23-ны өдөр багш нарын дунд “Боловсрол дах ёс зүйн асуудал” сэдэвт илтгэлийн уралдаан боллоо.

Цэцэрлэг: Олон улсын ЭКО- сургууль цэцэрлэг хөтөлбөрт хамрагдаж “ Хүрэл Гэрэгэ” авах болзолгоо амжилттай ханган ажилласан.

“Тэгш таван ухаан төв” ТББ, aplus.mn цахимаар модуль сургалтыг зохион байгуулж манай байгууллагын нийт 12 багш, аргазүйч, нар хамрагдаж эхний нэг сургалтынхаа “Батламж ”-г амжилттай аваад байна.

Туслах багш нар хамтран бага насны хүүхдийн ярих чадвар, үгийн баялаг нэмэгдүүлэх, дүрд хувиран тоглох чадваруудыг дэмжих ажлын хүрээнд үлгэрээр сургалтын хэрэглэгдэхүүн хийсэн.

Мөн байгууллагын дэргэдэх залуучуудын баг хамт олон энэ сарын 26 ны өдөр “Залуус бид- Хайр түгээе” эртэч өглөө үйл ажиллагааг зохион байгуулсан.

Бага насны хүүхдийг амттанаар биш амин дэмээр дэмжие аянд Дархан Бадрах ХХК-ний хүнсний дэлгүүр найруулдаг аарц, чацаргана, Дөлгөөн Фарм ХХК эмийн сан нь витамин, вакусаар тус тус багш ажилчид болон хүүхдүүдийн дархлааг дэмжин нийт 600 мянган төгрөгийн хүнсний бүтээгдэхүүний дэмжлэг үзүүлсэн.

Эрүүл мэндийн сайдын 2022.03.15 ны А139 тушаалын дагуу эрт илрүүлэгийн үзлэгт 13 багш, ажилчдыг аймгийн нэгдсэн эмнэлэгт үзлэг оношилгоонд хамруулсан.

Соёл: Соёл урлагийн 9 үйл ажиллагаа зохион байгуулж 1606 хүн бусад үйл ажиллагаанд 354 хүн хамрагдсан байна.

Соёлын төвийн номын сан нь ажлын 8 цагаар тогтмол ажиллаж уншигч үйлчлүүлэгчдэд гэрээр болон танхимаар ном олгож ажиллаа.

12 - р сард байнгын уншигч 35, ирэгсэд 176 хүнд 234 ном гэрээр олгож 8 хүнд утсаар болон амаар лавлагаа өгч 18 татгалзал бүртгэлээ.

Хүүхэд залуучуудын Гэгээн Театрын “ИНЭЭД БЭЛЭГЛЭХ АЯН-2022” тоглолтыг хүлээн авч хүүхэд багачуудад хүргэлээ.

Соёлын тэргүүний ажилтан дуучин Дэлгэртөрийн “Хүний маань дээд ээж минь” аялан тоглолтыг хүлээн авч тоглууллаа.

Шинэ жилийн баяртай холбогдуулан “Ахмадын шинэ жил”, “Жаргалтай шинэ жил”, “Happy Night” хөтөлбөрт цэнгүүн, “Болор сарнай” залуучуудын цэнгүүн, “Бооцоот караоке” тэмцээн, “Сүлд модны наадам” зэрэг үйл ажиллагаа зохион байгуулан ажиллаа

Ард иргэд хүүхэд багачуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, ном унших дадал хэвшилд сургах зорилгоор "Судар эгшиглэн" төслийг сумын хэмжээнд дүгнэж, ангилал тус бүрд оны шилдэг уншигчаа шагнаж урамшуулсан. "Судар эгшиглэн" төслийн аймгийн хэмжээний шалгаруулалтанд оролцсон оролцогчдоос насанд хүрэгчдийн ангилалд 1, ахлах ангийн ангилалд 1 уншигч 4 дүгээр байрт, дунд ангийн ангилал 1 сурагч нэрэмжит шагналаар тус тус шалгарлаа. 5 сурагч тэргүүний уншигч Нацагдорж тэмдэгээр шагнагдлаа.

Номын сангийн нэгдсэн Lib4U программд фондын номуудаа шивж оруулж байна. Номын сангийн ажлын тайлан мэдээг холбогдох газруудад цаг тухайд нь хүргэж, 2022 оны ажлаа дүгнүүлж аймагтаа 2 дугаар байранд шалгарсан.

Тав: Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн хүрээнд:

Байгаль орчин БОАЖГазраас зохион байгуулсан “Байгалийн орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ыг хэрэгжүүлэх сургалт болон “БОХ арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн сан”-ийн сумын түвшний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналтын маягттай ажиллах сургалтад сумын ЗД, БОХУБ, БХ, Газрын даамал, Татварын байцаагч, Төрийн сангийн дарга нар цахимаар 2 удаагийн сургалтанд хамрагдсан бөгөөд хуулийн хугацаанд нь сумын байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээр санхүүжүүлэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөө болон зарцуулалтыг холбогдох маягтын дагуу гаргаж төсөв, зардлын мэдээллийн санд оруулан батлууллаа.

Сумын байгалийн нөөц ашигласны төлбөрийн давсан орлогын хэсгээр санхүүжүүлэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөнд нийт 122,688,000 төгрөгийг тусгаж булгийн эхийг хашиж хамгаалах, тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулах, нэгдсэн хогийн цэгийн цэгцэлсэн талбайг хашаажуулах, зэрэг арга хэмжээнүүдэд зарцуулахаар тусгалаа.

Нүдэнгийн уул, зуухийн айраг, Дөхөмийн бор овоо баянгийн овоо зэрэгт дамнан нутагшиж байгаа 18 аргал хонинд 2 удаагийн давтамжтай 120 ширхэг ногоон өвсийг тавьж биотехникийн арга хэмжээг авч ажиллаа. Биотехникийн арга хэмжээг авч ажилласнаар 22 болж өссөн дүнтэй байна

Хөдөө аж ахуй: 2022 оны жилийн эцсийн өрх, хүн ам болон мал тэжээвэр амьтдын тооллого 2022 оны 12 дугаар сарын 07- 17 ны өдрүүдэд явагдаж, сумын

хэмжээнд нийт мал 565805 толгой мал тоологдож, өмнөх оноос 42734 толгой малаар өссөн.

Өвөлжилтийн байдал хүндэрсэнтэй холбогдуулан аймгийн аюулгүй нөөцийн 900 боодол өвс, 400 ш тэжээлийг баг бүрт хуваарилж хөнгөлөлттэй үнээр малчдад олгосон.

2022 оны 12 сарын 25 - ний өдрийн байдлаар 36 зээлдэгчийн 225,1 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Үүнээс хэвийн 23 зээлдэгчийн – 147,4 сая төгрөг, хэвийн бус 2 зээлдэгчийн 1,8 сая төгрөг, эргэлзээтэй 1 зээлдэгчийн 1,0 сая төгрөг, чанаргүй 10 зээлдэгчийн – 74,9 сая төгрөг байна.

Тухайн онд 61,7 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 64,7 сая төгрөгийн зээл, зээлийн хүүгийн орлого төвлөрч хэвийн зээлийн эргэн төлөлт 105 % - тай байна.

Нэгтгэсэн: ХЭЗХ-мэргэжилтэн

Ж.Долгорсүрэн